



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
О.БАТНАЙРАМДАЛ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026. 07. 30 № ХХТ/2568
танай _____-ны № _____-т

Асуултын хариу хүргүүлэх тухай

Таны 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 28 дугаар албан бичгээр ирүүлсэн асуултын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Жич: cd 4 ширхэг.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР

000265007031

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2026 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн
ХТ/1568 дугаар албан бичгийн
1 дүгээр хавсралт

АСУУЛТЫН ХАРИУ

Аж үйлдвэр эрдэс баялгийн яам, Ашигт малтмал, газрын тосны газраас болон “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-аас ирүүлсэн баримт, материалыг нэгтгэн асуултын хариуг хүргүүлж байна.

1. "Оюу толгой" ХХК-ийн 2024-2025 оны хараат бус аудитаар баталгаажсан санхүүгийн дэлгэрэнгүй тайлангийн талаар

“Оюу толгой” ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд “Кэй Пи Эм Жи Аудит” ХХК хараат бус аудит хийж, уг тайлан нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, мөн тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэж дүгнэсэн байна.

Мөн 2025 оны санхүүгийн тайлангийн хараат бус аудитораар “Нексиа Глобал Монголиа Аудит” ХХК ажиллаж, санхүүгийн тайлангууд нь тухайн санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан гэж дүгнэсэн байна.

Хавсралт: cd диск

1.1. “Оюу толгой” ХХК-ийн 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан.

1.2. “Оюу толгой” ХХК-ийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан.

2. "Оюу толгой" ХХК-ийн 2024-2025 оны төсөв, төсвийн гүйцэтгэл, менежментийн тайлан, дүгнэлт, нийт борлуулалт, үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардлын задаргаа, ашигт ажиллагаа, мөнгөн урсгал, хөрөнгө оруулалт, ашгийн хуваарилалтын талаарх мэдээлэл

2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаар

“Оюу толгой” ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангаас харахад нийт хөрөнгийн хэмжээ 18.4 тэрбум ам.доллар байсан бөгөөд үүнээс эргэлтийн бус хөрөнгө 17.8 тэрбум ам.доллар, эргэлтийн хөрөнгө 542.7 сая ам.долларыг тус тус эзэлж байна.

Тайлант жилийн эцсийн байдлаар нийт өр төлбөр 19.6 тэрбум ам.доллар байсан бөгөөд үүнээс урт хугацаат өр төлбөр 18.8 тэрбум ам.доллар, богино хугацаат өр төлбөр 711.9 сая ам.доллар байна. Эздийн өмч (1.18) тэрбум ам.доллар байсан байна.

2024 онд нийт борлуулалтын орлого 2.18 тэрбум ам.доллар, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 1.11 тэрбум ам.доллар байсан бөгөөд нийт ашиг 946.9 сая ам.долларт хүрсэн байна. Ерөнхий болон удирдлагын зардал 603.4 сая ам.доллар, санхүүгийн зардал 1.63 тэрбум ам.доллар байсан бөгөөд тайлант жилийн цэвэр алдагдал 1.26 тэрбум ам.доллар байна.

Мөнгөн гүйлгээний тайлангаас харахад үндсэн үйл ажиллагаанаас 599.2 сая ам.долларын цэвэр мөнгөн урсгал бий болсон бөгөөд хөрөнгө оруулалтын үйл

ажиллагаанд 1.3 тэрбум ам.доллар зарцуулсан байна. Тайлант хугацаанд компани сөрөг чөлөөт мөнгөн урсгалтай ажилласан бөгөөд, хувь нийлүүлэгчдээс 801 сая ам.долларын, гуравдагч талаас 70 сая ам.долларын нэмэлт санхүүжилт авч, ахлах эрэмбийн зээлийн хүүд 483 сая ам.доллар төлсөн бөгөөд ногдол ашиг хуваарилаагүй байна.

2025 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаар

“Оюу толгой” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангаас харахад нийт хөрөнгийн хэмжээ 20.4 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 1.99 тэрбум ам.доллараар өссөн байна. Тайлант жилийн эцсийн байдлаар нийт өр төлбөр 20.5 тэрбум ам.доллар, эздийн өмч (167.8) сая ам.доллар байна.

Тайлант хугацаанд компанийн нийт борлуулалтын орлого 4.99 тэрбум ам.доллар, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 1.67 тэрбум ам.доллар байсан бөгөөд нийт ашиг 3.07 тэрбум ам.долларт хүрсэн байна. Ерөнхий болон удирдлагын зардал 347.8 сая ам.доллар, санхүүгийн зардал 1.67 тэрбум ам.доллар байсан бөгөөд тайлант жилийн хүү татвар, элэгдлийн өмнөх ашиг (EBITDA) 3.47 тэрбум ам.доллар, цэвэр ашиг 1.01 тэрбум ам.доллар байна.

Мөнгөн гүйлгээний тайлангаас харахад үндсэн үйл ажиллагаанаас 3.3 тэрбум ам.долларын цэвэр мөнгөн урсгал бий болсон бөгөөд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд 1.3 тэрбум ам.доллар зарцуулсан байна. Тайлант хугацаанд зээл болон санхүүжилттэй холбоотой төлбөрүүдийг гүйцэтгэсний дараа санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал (570.0) сая ам.доллар байсан бөгөөд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эхний 126.6 сая ам.доллараас өсөж, оны эцэст 947.1 сая ам.долларт хүрсэн байна.

Тайлант жилийн эцсийн байдлаар нийт өр төлбөр 20.5 тэрбум ам.доллар байсан бөгөөд үүнээс хувь нийлүүлэгчдийн зээл 12.5 тэрбум ам.доллар, төслийн санхүүжилтийн зээл 3.79 тэрбум ам.доллар, спонсорын давуу эрхтэй зээл 1.6 тэрбум ам.доллар, урьдчилгаа төлбөрийн санхүүжилт 1.6 тэрбум ам.доллар, эргэлтийн хөрөнгийн санхүүжилт 0.07 тэрбум ам.долларыг тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд үндсэн зээлийн эргэн төлөлтөд 476 сая ам.доллар, зээлийн хүүгийн төлбөрт 562 сая ам.доллар зарцуулсан бөгөөд ногдол ашиг хуваарилаагүй байна.

2024, 2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон төсөв батлах тухай “Оюу Толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолууд, төсвийн гүйцэтгэлийн тайлан, компанийн үйл ажиллагааны жилийн тайлан, Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, зээл, санхүүжилтийн талаарх мэдээллийг 2.1.1-2.5 дугаар хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: cd диск

2.1.“Оюу толгой” ХХК-ийн 2024-2025 оны төсөв, төсвийн гүйцэтгэл, менежментийн тайлан, дүгнэлт, нийт борлуулалт, үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардлын задаргаа, ашигт ажиллагаа, мөнгөн урсгал, хөрөнгө оруулалт, ашгийн хуваарилалт (эргэн хөрөнгө оруулалт, зээлийн эргэн төлөлт, ногдол ашиг гэх мэт)-ын талаарх мэдээлэл.

3. “Оюу толгой” ХХК-ийн 2024-2025 онд Рио Тинто болон түүний хамаарал бүхий этгээдүүдэд шилжүүлсэн төлбөр, бүртгэсэн зардал, зээлийн талаарх мэдээлэл

“Оюу толгой” ХХК нь 2024-2025 онд Рио Тинто болон түүний хамаарал бүхий этгээдүүдэд нийт 1,217 сая ам.долларын төлбөр шилжүүлсэн байна. Үүнд зээлийн үндсэн төлбөрт 376.4 сая ам.доллар, зээлийн хүү болон шимтгэлийн төлбөрт 349 сая ам.доллар, баталгааны шимтгэлд: 149.3 сая ам.доллар, менежментийн үйлчилгээний төлбөрт 287.1 сая ам.доллар, Рио Тинтогийн ажлын даалгаврын (Statement of Work) төлбөрт 55.1 сая ам.доллар тус тус шилжүүлсэн байна.

Мөн 2024-2025 онд Рио Тинто болон түүний хамаарал бүхий этгээдүүдтэй холбоотой нийт 3,625.5 сая ам.долларын зардлыг бүртгэсэн байна.

Үүнээс зээлийн хүү болон шимтгэлийн зардал 3,087.3 сая ам.доллар, баталгааны шимтгэлийн зардал 149.3 сая ам.доллар, менежментийн үйлчилгээний зардал 335.6 сая ам.доллар, Рио Тинтогийн ажлын даалгаврын (Statement of Work) үйлчилгээний зардал 53.3 сая ам.доллар байна.

Хавсралт: cd диск

3.1 “Оюу толгой” ХХК-ийн 2024-2025 оны Рио Тинто болон түүний хамаарал бүхий этгээдүүдэд шилжүүлсэн зардал.

4. “Оюу толгой” ХХК-ийн 2026-2030 оны олборлолт, баяжмал үйлдвэрлэл, борлуулалт, зардал, ашиг, мөнгөн гүйлгээний төсөөлөл, хэтийн төлөвлөгөө, стратегийн зорилт болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн талаарх мэдээлэл

“Оюу толгой” ХХК нь 2026-2030 оны бизнес болон үйлдвэрлэлийн таван жилийн цогц төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу боловсруулж, 2025 оны 6 дугаар сарын 8-ны өдөр “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-д хүргүүлсэн байна.

Тус төлөвлөгөөнд зах зээлийн төлөв, стратегийн зорилт, уурхайн үйлдвэрлэлийн төлөвлөлт, санхүүгийн төсөөлөл болон үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг тусгасан байна.

Төлөвлөгөөнд дурдсанаар ээсийн эрэлт дунд болон урт хугацаанд өсөх төлөвтэй гэж үзсэн бөгөөд компанийн урт хугацааны стратеги төлөвлөгөөнд үндэслэн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлсон байна.

Уурхайн үйлдвэрлэлийн төлөвлөлт нь шинэчилсэн загвар, олборлолтын дараалал, үйл ажиллагааны үндсэн таамаглалд тулгуурласан бөгөөд 2030 он хүртэлх үйлдвэрлэлийн хэтийн төлөвийг 5Q1 төлөвлөлтийн хувилбарт үндэслэн боловсруулжээ.

Санхүүгийн төсөөллөөр 2026-2030 онд борлуулалтын орлого жил бүр 1-10 хувиар өсөх, нэгжийн нийт зардал жил бүр 4-14 хувиар буурах, таван жилийн хугацаанд нийт 11 тэрбум ам. долларын чөлөөт мөнгөн урсгал бий болохоор төлөвлөсөн байна.

Мөн 2026-2028 онд далд уурхайн хоёр панелийн бүтээн байгуулалтыг зэрэг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хавсралт: cd диск

4.1 “Оюу толгой” ХХК-ийн таван жилийн бизнес төлөвлөгөө

5. “Оюу толгой” ХХК-ийн 2026 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэр, мөн

2026 онд хэлэлцэх болон танилцуулахаар төлөвлөж буй асуудлуудын талаарх мэдээлэл

“Оюу толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2026 онд нэг удаа ээлжит хурал зохион байгуулсан бөгөөд ээлжит бус хурал хийгээгүй байна. Ээлжит хуралд төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч гишүүд оролцсон бөгөөд тус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Нэгдүгээрт, “Оюу толгой” ХХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийн төслийг хэлэлцэж, гишүүдийн гаргасан санал, зөвлөмжийг тусган засварлах нөхцөлтэйгөөр холбогдох тогтоолыг баталсан.

Хоёрдугаарт, хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр Төлөөлөн удирдах зөвлөлийн зарим гишүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар 2026 онд хэлэлцэх болон танилцуулахаар төлөвлөж буй асуудлуудын талаарх мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: cd диск

5.1 “Оюу толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2026 онд баталсан тогтоолууд.

5.2 “Оюу толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төлөвлөгөө.

6. “Оюу толгой” ХХК, “Онтрэ” ХХК-ийн нөөцийн тайлан, техник, эдийн засгийн үндэслэл, уулын ажлын төлөвлөгөө болон “Онтрэ” ХХК-ийн эзэмшилд буй тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлын талаарх мэдээлэл

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 120 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд стратегийн ач холбогдол бүхий Оюу толгой бүлэг ордын талбайн хилийн заагт орших “Жавхлант”, “Шивээ толгой” ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбогдсон шийдвэр, ажиллагааны хууль зүйн үндэслэл, хуульд нийцсэн байдлыг нягтлах ажлыг Ашигт малтмал, газрын тосны газраас гүйцэтгэж байгаа бөгөөд одоогийн байдлаар санал, дүгнэлт эцэслээгүй байна.

Оюутолгойн зэс-алтны бүлэг ордын нөөцийн тооцоо, техник, эдийн засгийн үндэслэлтэй холбоотойгоор 2009, 2015 болон 2021 онд ордын нөөцийг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн байна. Үүнд:

- Оюу толгойн зэс-алтны бүлэг ордын хэмжээнд 2000-2008 онд “Айвенхоу Майнз Монголиа Инк” ХХК хайгуул хийж, нөөцийг тооцоолон Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2009 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 167 тоот тушаалаар тус ордын нөөцийг бүртгүүлсэн. (Нөөцийн тайлан 2009)
- “Оюу толгой” ХХК нь 2009 онд бүртгүүлсэн нөөцөд тулгуурлан Оюутолгойн бүлэг ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ 2010) тайланг боловсруулж ЭБМЗ-ийн 2010 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлж, хүлээлгэн өгсөн.
- 2009-2014 онд Оюу толгойн зэс-алтны бүлэг ордын хэмжээнд хайгуулын ажил гүйцэтгэсэн, нөөцийн тодотгол тооцооны тайланг (Нөөцийн тайлан 2014) боловсруулан АМГ-ын 2015 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 10 тоот тушаалаар бүлэг ордын нөөцийг бүртгүүлсэн.

- “Оюу толгой” ХХК нь 2015 онд Оюутолгойн бүлэг ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол (ТЭЗҮ 2015) тайланг боловсруулж, ЭБМЗ-ийн 2015 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлж, ТЭЗҮ-г Ашигт малтмалын газрын даргын 2015 оны 11 сарын 06 өдрийн т/109 дугаартай тушаалаар хүлээн авсан.
- “Оюу толгой” ХХК нь бүлэг ордын хэмжээнд 2015-2018 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнд нөөцийн тодотгол (Нөөцийн тайлан 2019) тайланг боловсруулж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 20-ний өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлж, Үндэсний геологийн албаны даргын 2021 оны 12 дугаар сарын 16-ний өдрийн А/125 дугаартай тушаалаар нөөцийг хүлээж авч бүртгэсэн байна.
- Улмаар “Оюу толгой” ХХК нь уг нөөцөд тулгуурлан техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол (ТЭЗҮ 2023) тайланг боловсруулан, ЭБМЗ-ийн 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлсэн боловч 13 асуудлыг засаж, сайжруулахаар буцаасан. Үүнд “Онтрэ” ХХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах нөөц, менежментийн үйлчилгээний төлбөр, зээлийн хүүг бууруулах зэрэг хувьцаа эзэмшигч талуудын хэлэлцээтэй холбоотой шийдвэрлэх асуудлуудыг тусгасан байдаг.

Хавсралт: cd диск

6.1.Дээр дурдсан Оюутолгойн бүлэг ордын нөөцийн тайлангууд (2009, 2014, 2019), техник, эдийн засгийн үндэслэлүүд (ОТТЭЗҮ 2010, ОТТЭЗҮ 2015, ОТТЭЗҮ 2023) болон 2026 оны уулын ажлын төлөвлөгөө.

Мөн Оюу толгойн зэс-алтны бүлэг ордын талбайд тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа “Оюу толгой”, “Онтрэ” ХХК-ийн 2026 оны уулын ажлын төлөвлөгөө, геологи хайгуулын ажлын үр дүнгийн тайлан болон Техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, хүлээн авсан дүгнэлт, тушаалын хуулбар.

---oOo---



Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2026 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн
ХТ/2568... дугаар албан бичгийн
2 дугаар хавсралт

АЛБАН БИЧГИЙН /CD/ ХАВСРАЛТЫН ТОВЬЁГ

№	Албан материалын нэр	Тайлбар	Хуудасны тоо
1	"Оюу толгой" ХХК-ийн 2024-2025 оны хараат бус аудитын компаниар аудитлагдсан, баталгаажсан санхүүгийн дэлгэрэнгүй тайлан (санхүүгийн байдлын тайлан, орлого, зарлагын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон жилийн санхүүгийн тайлангийн тодруулга) талаар		
1.1	ОТ ХХК-ийн 2024 оны аудитлагдсан, баталгаажсан СТ	Санхүүгийн байдлын тайлан, орлого, зарлагын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон жилийн санхүүгийн тайлангийн тодруулга	80
1.2	ОТ ХХК 2025 оны аудитлагдсан, баталгаажсан санхүүгийн тайлан		80
2	"Оюу толгой" ХХК-ийн 2024-2025 оны төсөв, төсвийн гүйцэтгэл, менежментийн тайлан, дүгнэлт, нийт борлуулалт, үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардлын задаргаа, ашигт ажиллагаа, мөнгөн урсгал, хөрөнгө оруулалт, ашгийн хуваарилалт (эргэн хөрөнгө оруулалт, зээлийн эргэн төлөлт, ногдол ашиг гэх мэт)-ын талаарх мэдээлэл		
2.1.1	ОТ ХХК-ийн 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон төсөв батлах тухай ТУЗ-ийн тогтоол		7
2.1.2	ОТ ХХК-ийн 2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон төсөв батлах тухай ТУЗ-ийн тогтоол		5
2.1.3	ОТ ХХК-ийн 2024 оны төсвийн гүйцэтгэл	ОТ ХХК-аас ирүүлсэн 2024 оны 12 сарын ТУЗ-ийн материал	62
2.1.4	ОТ ХХК-ийн 2025 оны төсвийн гүйцэтгэл	ОТ ХХК-аас ирүүлсэн 2025 оны 12 сарын ТУЗ-ийн материал	37
2.2	ОТ ХХК 2024 оны жилийн тайлан	ОТ ХХК-ийн 2024 оны үйл ажиллагааны жилийн тайлан	18
2.3.1	ОТ ХХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн ТУЗ-ийн дүгнэлт_13 March 2025 Mon	ОТ ХХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн ТУЗ-ийн дүгнэлт тогтоол	19
2.3.2	ОТ ХХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн ТУЗ-ийн дүгнэлт_05 Mar 2026 Mon	ОТ ХХК-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн ТУЗ-ийн дүгнэлт тогтоол	18
2.4	ОТ ХХК 2025 оны жилийн тайлан	ОТ ХХК-ийн 2025 оны үйл ажиллагааны жилийн тайлан	78
2.5	ОТ ХХК-ийн зээлийн мэдээлэл	2024, 2025 оны байдлаарх зээлийн үлдэгдэл, эргэн төлөлтийн мэдээлэл	1
3	"Оюу толгой" ХХК-ийн 2024-2025 онд Рио Тинто компани, түүний хамаарал бүхий этгээдүүдэд шилжүүлсэн ба шилжүүлэхээр бүртгэсэн зардал, зээлийн талаарх мэдээллүүд		
3.1	ОТ ХХК-ийн 2024-2025 оны Рио Тинто компани,	2026.06.08-нд ОТ ХХК-аас ирүүлсэн 2024-2025 оны Рио Тинто компани, түүний	5

	түүний хамаарал бүхий этгээдүүдэд шилжүүлсэн зардал	хамаарал бүхий этгээдүүдэд шилжүүлсэн зардал 2024, 2025 оны хамааралтай талын хэлцлийн зардлууд	
3.2	ОТ ХХК-ийн зээлийн талаарх мэдээллийг 2.5-д оруулсан.		
4	"Оюу толгой" ХХК-ийн 2026-2030 оны олборлолт, баяжмал үйлдвэрлэл, борлуулалт, зардал, ашиг, мөнгөн гүйлгээний төсөөлөл, хэтийн төлөвлөгөө, компанийн стратегийн зорилтууд болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд (KPI)-ийн талаар		
4.1	ОТ ХХК-ийн 5 жилийн бизнес төлөвлөгөө	2025 оны 6 сарын 3-нд ТУЗ-д танилцуулсан 5 жилийн бизнес төлөвлөгөө (ОТ ХХК-аас шинэчлэгдэж байгаа гэсэн мэдээллийг өгсөн)	20
4.2	ОТ ХХК-ийн 2026 оны гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		1
5	"Оюу толгой" ХХК-ийн 2026 оны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэрийн талаарх мэдээлэл болон 2026 онд хэлэлцэх болон танилцуулахаар төлөвлөж буй асуудлуудын талаар		
5.1	ОТ ХХК-ийн 2026 оны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол	2026 онд ОТ ХХК-ийн ТУЗ-өөс батлагдсан тогтоолууд	34
5.2	ТУЗ-ийн 2026 оны төлөвлөгөө		1
6	"Оюу толгой" ХХК, "Онтрэ" ХХК-ийн нөөцийн тайлан, техник, эдийн засгийн үндэслэлүүд, уулын ажлын төлөвлөгөө болон 2026 онд холбогдох төрийн байгууллагуудаас "Онтрэ" ХХК-ийн эзэмшилд буй тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар гаргасан шийдвэрүүд, ажлын хэсгийн тайлан, дүгнэлт, үр дүнгийн талаарх мэдээлэл.		
6.1	MV-015226 Шивээ толгой талбайд үйл ажиллагаа явуулахгүй тухай мэдэгдэл	"Онтрэ" ХХК-ийн MV-015226 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Шивээ толгой талбайд үйл ажиллагаа явуулахгүй тухай мэдэгдэл	1
6.2	MV-015225 Жавхлант талбайд үйл ажиллагаа явуулахгүй тухай мэдэгдэл	"Онтрэ" ХХК-ийн MV-015225 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Жавхлант талбайд үйл ажиллагаа явуулахгүй тухай мэдэгдэл	1
6.3	Нөөцийн тайлан 2009	Оюу толгойн бүлэг ордын нөөцийн тайлан 2009	480
6.4	Нөөцийн тайлан 2014	Оюу толгойн бүлэг ордын нөөцийн тайлан 2014	443
6.5	Нөөцийн тайлан 2019	Оюу толгойн бүлэг ордын нөөцийн тайлан 2019	561
6.6	ТЭЗҮ 2010	Оюу Толгойн бүлэг ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэл 2010	1,050
6.7	ТЭЗҮ 2015	Оюу Толгойн бүлэг ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэл 2015	1,519
6.8	ТЭЗҮ 2023	Оюу Толгойн бүлэг ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэл 2023	1,408
6.9	OP_UG_integrated_AMP26	Оюу толгой ордын 2026 оны уулын ажлын төлөвлөгөө	229
6 дугаар асуулттай холбоотой Ашигт малтмал, газрын тосны газраас ирүүлсэн материал			
1.	Оюу толгойн зэс-алтны үндсэн ордын ил аргаар ашиглах Өмнөд Оюугийн орд /Хэсэг/-ын нөөц хүлээн авсан ЭБМЗ-ийн дүгнэлт, АМГТХЭГ-ын даргын тушаал./2007 он/	Оюу толгой ХХК	1-р CD

2.	Өмнөд Оюугийн бүлэг ордын нөөцийн тодотгол, Хюга Дамметтийн бүлэг орд болон Херуга ордын нөөц хүлээн авсан ЭБМЗ-ийн дүгнэлт, ЭБЭХ-ний сайдын тушаал. /2009 он/	Оюу толгойн зэс-алтны бүлэг ордод хамаарах "Оюу толгой" ХХК-ийн MV-006709, "Онтрэ" ХХК-ийн XV-003148 /Хойд Хюго ордын хойд үргэлжлэл/, XV-003150 /Херуга орд/ тусгай зөвшөөрлүүдийн талбайд нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэсэн	1-р CD
3.	Оюу толгойн зэс-алтны бүлэг ордын Оюут, Хюга Дамметт, Херуга ордын нөөцийн тодотгол хүлээн авсан ЭБМЗ-ийн дүгнэлт, АМГ-ын даргын тушаал. /2015 он/	Оюут /MV-006709/, Херуга /MV-006709, MV-015225/, Хюга Дамметт /MV-006709, MV-015226/ ордуудад 2009-2014 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлын нөөцийн тодотгол	1-р CD
4.	Оюу толгойн зэс-алтны бүлэг ордын нөөц хүлээн авсан ЭБМЗ-ийн дүгнэлт, УГА-ны даргын тушаал. /2021 он/	Оюу толгой ХХК-ийн MV-006709, "Онтрэ" ХХК-ийн MV-015225, MV-015226 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдтэй Оюу толгойн зэс-алтны бүлэг ордод 2019 онд нөөцийн шинэчилсэн тооцоолол хийсэн нөөц	1-р CD
5.	Оюу толгойн зэс-алтны бүлэг үндсэн ордыг ашиглах уурхай, баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ний дүгнэлт, тушаал /2010 он/	Оюу толгой ХХК, ОНТРЭ ХХК	2-р CD
6.	Оюу толгойн зэс-алтны бүлэг ордыг ашиглах ТЭЗҮ-н тодотголын дүгнэлт, тушаал /2015 он/	Оюу толгой ХХК-ийн MV-006709, "Онтрэ" ХХК-ийн MV-015225, MV-015226 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлттэй Оюу толгойн зэс-алтны бүлэг (Оюут, Хюга Дамметт, Херуга) ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотгол	2-р CD
7.	Уулын ажлын төлөвлөгөө /2026 он/	Оюу толгой ХХК	3-р CD
8.	Уулын ажлын төлөвлөгөө (X) /2026 он/	"Онтрэ" ХХК	3-р CD
9.	Уул уурхайн сайдын 43 тоот тушаал /2013 он/	Тушаал хүчингүй болгох тухай	3-р CD
10.	Уул уурхайн сайдын 179 тоот тушаал /2013 он/	Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	3-р CD
11.	АМГ-ын даргын 373 тоот тушаал /2013 он/	Нөөц бүртгэх тухай	3-р CD